

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Аюурын Банзрагч	Дугаар	L205
Оршин суугаа аймаг	Дорноговь	Оршин суугаа сум	Хатанбулаг сум 1-р баг
Төрсөн газар	Хатанбулаг сум	Төрсөн он	1923
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хоньчийн хийд, Өлгийн хийд	Сүм хийдийн дугаар	ДГМН 094, ДГМН 095
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 24	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Дорноговь аймгийн Мандах сумын Хоньчийн хийд, Өлгийн хийд

За Банзрагч гуай, та аль хийдэд шавилан сууж байсан хүн бэ, хэдэн наснаасаа хэдэн нас хүртлээ?

Банзрагч: Аа Хоньчийн хийдэд эхлээд сууж байсан. Тэгээд Өлгийд шилжээд оччихсон.

Гантулга: Хэдэн настай шавилан суусан бэ, хуралд?

Банзрагч: За ер нь ...мэдэхгүй л байна.

Гантулга: Багцаагаар л хэлчихгүй юу?

Банзрагч: Багцаагаар уу?

Гантулга: Тийм.

Банзрагч: Тэгвэл нэг найм, есөн настай л суусан болов уу.

Гантулга: Энэ Хоньчийн хурлыг өөрөөр юу гэж нэрлэдэг байсан бэ?

Банзрагч: Тэр нэрийг нь мэдэхгүй юм.

Гантулга: Дацангийн одоо нэрүүд байдаг ш дээ, Төвдөөр пайзан дээр биччихсэн. Тийм нэр байсан л байх даа?

Банзрагч: Чойр, Жүд, Дүйнхор гээд үү?

Гантулга: Үгүй зүгээр Гандан энэ тэр гээд?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Банзрагч: Мэдэхгүй.

Гантулга: Энэ хэзээ хэдий үед ямар хүн байгуулсан хийд вэ? Тэрний талаар дуулсан уу, та?

Банзрагч: Дуулаагүй.

Гантулга: Энэ хуучин захиргаагаараа аль аймгийн аль хошуунд хамаарч байсан хийд вэ?

Банзрагч: Энэ Мэргэн Вангийн хошуу, Дорноговийн нутагт.

Гантулга: Хийдийн ойролцоо байгаа газар усыг ,тахидаг барьдаг юмуу эсвэл тийм уул усны нэрээр нь нэрлэвэл ямар газар байна? Эргэн тойронд, хамгийн ойр?

Банзрагч: Эргэн тойронд нь уу, Баян Хайрхан гэж бий.

Гантулга: Тэр хаанаа байдаг хайрхан бэ?

Банзрагч: Баруун урдаа байдаг.

Гантулга: Өөр ус, булаг?

Банзрагч: Булаг ч одоо холдоо, Нарангийн булаг гэж байсан.

Гантулга: Ойрхон худаг ,ус байсан байлгүй дээ?

Банзрагч: Аа ойрхон уу, замын худаг гэж байсан. Чойрын ус гэж байсан, тэр баёруун өмнөө.Лянх хурдаг газар.

Гантулга: Тэр хошууны ноёныг та мэдэх үү, нэрийг нь?

Банзрагч: Мэдэхгүй.

Гантулга: Тийм нэртэй хүн байсан гэж?

Банзрагч: Мэргэн вангийн хошууны л гэж явдаг байсан.

Гантулга: Ер нь газрынх нь байршил, уул толгодын дунд байна уу, тэгшхэн хавтгай талбайд байна уу?

Банзрагч: Уул хадшуу нутаг байна, эргэн тойрондоо бол. Зүүн талдаа бол уул байхгүй.

Гантулга: Аан, ар талд нь байгаа тэр уулынх нь нэрийг та хэлвэл?

Банзрагч: Ар талд...

Гантулга: Ардаа уултай юу, уулын өвөр дээр гэсэн биз дээ?

Банзрагч: Ер нь бол жаахан уул нь бол Зүүн Сүүж уул л юм даа.Тэр нь одоо ямар...

Гантулга:Ус, хад , овоо тийм юмных нь нэрийг хэлж өгөөч?

Банзрагч: Тийм юм дуулдаагүй ээ.

Гантулга: Ойр хавьдаа байхгүй юу?

Банзрагч. Байхгүй ээ.

Гантулга: Ойр хавьд нь байсан тэгвэл сүм хийдийнх нэр, ойрхон ингээд хорь гучин км-т байгаа?

Банзрагч: Аа тийм юм байхгүй. Тийм хорь гучин км-т.

Гантулга: Тавь жаран км-т ч байхгүй юу, ойрхон ирж очдог хийдүүдээ л гэж байгаа юм?

Банзрагч: Аа тийм. Тэгвэл ч Өлгий байна, тэр Өлзийтийн хурал байна, тэр хойших нь хойшоо нөгөө Мандахын Уул гээгээний хийд ч гэж байсан, тэндээс ирж очдог холбоотой их л хийд холбоотой байсан.

Гантулга: Хоньчийн хийдийн гол шүтээн бурхан нь ямар бурхан байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Банзрагч: Тэр Цамба, Дош өөр ч одоо ч ямар ямар бурхан байлаа даа. Мэдэхгүй...

Гантулга: Энэ шарын хийд байсан уу, шарын шашны хийд байсан уу?

Банзрагч: Шарынх байсан байх.

Гантулга: Улааных биш байсан уу?

Банзрагч: Биш байсан.

Гантулга: Олон лам хуврагтай хийд байсан уу?

Банзрагч: Аа бас нэг таван зуугаад ламтай байсан байх. Бүгд суугаад...

Гантулга: Аль хошуу хийдээс шавилж суудаг байсан бэ, улсууд?

Банзрагч: Өө газар бүрээс, хаа хаанаас ч ирдэг байсан юм мэдэхгүй.

Гантулга: Хутагт хувилгаан байсан уу, тэнд?

Банзрагч: Байсан.

Гантулга: Нэрлэвэл?

Банзрагч: Нэрлэвэл Дашжанцан гэж хувилгаан байсан. Лувсансамбуу гэж цорж хүн байсан. Тэгээд тэр хийдийг дааж, зохион байгуулж дааж авдаг даа лам нь гэхээр Жамц даа лам гэж байсан, миний үед. За ийм л улсууд лав байсан.

Гантулга: Энэтхэг, Төвдөөс том хутагт, хувилгаан нэртэй лам нар байсан уу?

Банзрагч: Аа дуулдаагүй.

Гантулга: Гэлэн сахилтай хүн бол олон байсан уу?

Банзрагч: Аан?

Гантулга: Гэлэн сахилтай хүн бол олон байсан уу?

Банзрагч: Аа олон байсан. Ахмадхан настай улсууд л дандаа л гавж л, гэлэн л гэдэг.

Гантулга: Нэртэй зурхайч, эмч маарамба, бурханч улсууд байсан уу?

Банзрагч: Үгүй ээ тэр, Лувсан лам гэдэг чинь чулууны мэргэ тавьдаг, олон янзаар мэргэлдэг л гэж улсууд ярьдаг байсан юм.

Гантулга: Аан өөр?

Банзрагч: Өөр одоо...

Гантулга: Маарамба?

Банзрагч: Маарамба дуулдаагүй ээ.

Гантулга: Бурханч одоо уран улсууд?

Банзрагч: Аа тийм үү, тийм улсууд ч одоо... Байсан л байх даа. Бурхан зурдаг улсууд гэж хүн ярьдаг л байсан юм.

Тэгэхдээ миний үед байв уу, үгүй юу...

Гантулга: Хамба лам, цорж лам, ловон, гэсгүй, үнзад, даа лам, нярав гээд улсуудаас нь нэгрлэвэл?

Банзрагч: Аа үнзад нь Дэндэд гэж хүн байсан. Даа лам нь тэр Жамц даа лам гэж байсан. Аа нярав нь, за байз нэрийг нь мартчихлаа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Яахав ээ яахав .Санахгүй бол хамаагүй ээ.

Банзрагч: За ...за санахгүй нь ээ.

Гантулга: Энэ Хоньчийн хурал хичнээн дацан дугантай байсан бэ, нэр нэрээр нь нэрлэвэл, тус бүрд нь ?

Банзрагч: Аа нэрлэвэл үү, за ...

Гантулга: Цогчин дуган?

Банзрагч: Тийм ээ, цогчин тэр хашаанд чинь нэг хоёр...Зургаан дуган байжээ, цогчин сүмийн хашаандаа.

Гантулга: Нэрлэвэл, хашаан дотроо юу?

Банзрагч: Тийм. Нэрлэвэл үү нэрлэвэл одоо тэр гол их шүтдэг нь шам, говийн лха гэж...

Гантулга: Сахиусны сүм байж?

Банзрагч: Тийм. Сахиусны сүм байсан юм. За тэгээд сүмээс хойш нэг хурал байдаг юм. Тэнд хурал хурдаг байсныг нь мэдэхгүй ээ. Зүүн талд одоо тэр буман жамын гээч нь юм уу, юу юм байшингийнхаа таазнаас авахуулаад байшингийнхаа шал хүртлээ эгнэсэн олон бурхан байсан юм.За тэр үүдэнд яахав махранд гэж нэг лут дөрвөн юм байдаг байсан юм.Бусад нь тэгээд жасаа масаахан юухан ийхэн хурдаг тийм жижиг сүмүүд л байсан юм.За тэр Дүчин эргэнэ гэдэг, Дүйнхорын сүм гэдэгт дүчин хийдэг байсан.

Гантулга: Дүйнхорын сүм нь хашаан дотроо юу, гаднаа юу?

Банзрагч: Гаднаа. Бүр тэр сондгой, тэр хойно.

Гантулга: Гал тогоо нь хаанаа байсан юм?

Банзрагч: Баруухантаа байсан юм.

Гантулга: Тэр Дүйнхор сүмээсээ юу?

Банзрагч: Тийм.

Гантулга: Мамба дацан байсан гэсэн, Мамба сүм?

Банзрагч :Аа тийм ,тэр чинь галын жас л гэж нэрлэдэг юм.Нэг л газрын жас нь галлаж тэр дүйнхор хурахад цай ундыг нь хийж өгдөг байсан юм.

Гантулга: Бас ядмын сүм гэж та хэлж байсан?

Банзрагч: Аа тийм , тэр чинь тэр Чойр сүмийн хойно байдаг юм.

Гантулга: Чойр сүм нь тэр баруун талдаа?

Банзрагч: Тийм, баруун талдаа сондгой байсан юм.

Гантулга: Айлууд нь хаагуураа байсан юм?

Банзрагч: Айлууд нь баруун талдаа сондгой Чойр л байна.Тэгээд зүүн тийшээ сүм айл хоёр нь үргэлжшүү л. Хашааны гадуур л байна даа одоо, цогчин сүмийн.

Гантулга: Энэ дацан дуганых нь нэрийг та тус бүрээр нь хэлж мэдэхгүй юу, оноосон нэр байхгүй юу?

Банзрагч: Байхгүй.

Гантулга: Тэрийг нь бол мэдэхгүй байна, тийм ээ?

Банзрагч: Мэдэхгүй байна. Тэр Мамба, Дүйнхор гэдгийг нь л яадаг юм гэхээс...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Суварга?

Банзрагч: Суварга ч байсан.

Гантулга: Хэдэн суварга байсан, хаагуураа байсан?

Банзрагч: За зүүн хойноо хоёр, гурав ,дөрөв...Тав байжээ.Тэр цогчин сүмээс өмнө нэг хүн эргэл мөргөл хийдэг нэг суварга байсан.Аа тэр гол дунд нэг өргөн чөлөө байдаг юм. Тэнд нэг сүм байдаг юм.Тэрнийг болвол хүн тасалдаггүй гэвэл арай үгүй байгаа ,тасалдаг л байлгүй. Шөнөдөө бүгд унтаж хононо.Бас хүн их л мөргөдөг, тийм онцгойлон мөргөдөг. Бусад суваргыг бол тойроод л өнгөрдөг ийм л байсан юм.

Гантулга: За за. Хоньчийн хурал дээр ер нь ном барладаг байсан уу?

Банзрагч: Ээ барлаж л байсан байх.

Гантулга: Ямар ном судар, ганжуур данжуур?

Банзрагч: Аа ганжуур данжуур юу байхав, өшөө өөрснийхөө л үздэг, тэр Чойр мойрынх нь байдаг юм уу, юуных нь байдаг юм. Ном барлаад л нэг л хүн аваад явж байсан.

Гантулга: Дацангуудад одоо, Чойрын дацанд нь Чойроо үзчихнэ тийм ээ?

Банзрагч: Тийм.

Гантулга: Дүйнхорт нь болохоор?

Банзрагч: Дүйнхорын чиглэлийнхээ номыг үзнэ.

Гантулга: Мамбад нь ?

Банзрагч: За тэгээд л Гүнрэг билүү, бас тэгээд л ...

Гантулга: Тэр жасаа уншдаг гээд бас нэг сүм хэлж байсан ?

Банзрагч: Тэр чинь цогчин сүмийн хашаанд өглөө болгон нэг жоохон ном уншаад л хоёр хүн гарч ирдэг.

Гантулга: Ядмынхаа сүмд?

Банзрагч: Ядмын сүм гэдэгт чинь ер нь хурал хурж байгаагүй. Тэр Чойр сүмийн хойхно байдаг юм.

Гантулга: Цогчин дугандаа ер нь хурал хурж байсан юм болов уу?

Банзрагч: Цогчинд уу?

Гантулга: Тийм.

Банзрагч:Тэр чинь гол их хурал чинь цогчин сүмдээ хурдаг.

Гантулга: Аа бүр байнгын хуралтай байна?

Банзрагч: Байнгын хуралтай байна.

Гантулга: Одоо энэ хашаан дотроо байгаа цогчин сүмдээ юу?

Банзрагч: Тийм.

Гантулга: Хэдэн лам багтдаг байсан тэнд?

Банзрагч: Аа нэлээн лам багтдаг байсан.

Гантулга: Мөрүүд дээрээ суухад уу?

Банзрагч: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ одоо дуган дацангийн зураг гэж байсан уу, тэр үед? Одоо энэ хүрээний ерөнхий тэг зураг гэж байсан уу, зурчихсан , бурханч лам нар зурсан?

Банзрагч: Үгүй ээ одоо тэр зурсан юм гэнэ лээ, энэ зурсан юм гэнэ лээ гээд бурхны тийм улсууд дуулддаг юмаа.

Гантулга: Үгүй ээ хийдийнхээ зургийг, ер нь?

Банзрагч: Аа тэр хийдээ нэлэнхүйд нь үү?

Гантулга: Тийм.

Банзрагч: Ээ мэдэхгүй.

Гантулга: Тийм юм бол та санахгүй байна уу?

Банзрагч: Санахгүй байна.Хийдийг зурсан...

Гантулга: Цогчин уншлагандаа ямар ном хурдаг байсан юм бол?

Банзрагч: Үгүй ээ, одоо л бодоход би чинь цогчинд гайгүй л хурсан хүн дээ.Тэгээд мартчихсан л байна ш дээ.

Лав л Итгэл Гандан, Дашзэвэг, Ламанчод энэ тэр лав л уншдаг байсан.

Гантулга: Сарын хурал, одоо шинийн найман, арван , арван таван?

Банзрагч: Дүйчэнгийн хурал хурж байсан.

Гантулга: Аан жилдээ болдог хурлууд нь ?

Банзрагч: Жилээсээ хэтэрч хурдаг хурлууд чинь одоо цагаан сарыг дөхүүлж байгаад л хуучны хурал гээд л хэд хоног хурдаг. Тэгээд арван таван шахдаг ч байж уу хэдийнээс юм , хурал тасрахгүй ээ дээ, тэнд.

Гантулга: Цам гардаг байсан уу, цамын бүжиг?

Банзрагч: Үгүй. Сор л зална.

Гантулга: Аа майдар эргэдэг байсан болов уу?

Банзрагч: Үгүй л байгаа юм. Ер майдар эргэнэ гэж байгаагүй.

Гантулга: Ганжуур эргэнэ гэж байсан уу?

Банзрагч: Ганжуур ч одоо улсууд зөндөө эргэнэ.

Гантулга: Мөргөлчид эргэх үү, лам нараасаа...?

Банзрагч: Мөргөлчид ч эргэнэ, лам нараасаа ч эргэнэ.

Гантулга: Гороогоор эргэх үү, өөр?

Банзрагч: Гороогоор эргэнэ.

Гантулга: Цагаан сарын хурал хэднээс эхлээд хэдэнд дуусдаг байсан юм бэ, өвлийн адаг сарын?

Банзрагч: Өвлийн адаг сарын арван тавдаасаа л эхэлж байсан болов уу.

Гантулга: Тэгээд ямар ямар номоо уншаад...?

Банзрагч: Аа мэдэхгүй.

Гантулга: Хэдүүд нь сороо залаад, тэр лхам мамаа хаанаа уншдаг байсан бол?

Банзрагч: Мэдэхгүй.

Гантулга: Мэдэхгүй байна уу, мартсан?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Банзрагч: Мартсан.

Гантулга: Дүйчэн өдрүүдээр бурхан багш, Богд ламын дүйчэн өдрөөр ямар ном хурдаг байсан бэ?

Банзрагч: Бас мэдэхгүй.

Гантулга: Хайлан хийдэг байсан уу?

Банзрагч: Хайланд цог өргөнө гээд л хонь ямаа алаад л хүн авчирчихсан байдаг байсан. Хайлан хийдэг л газар байна.

Гантулга: Нүгнээ сахидаг байсан уу?

Банзрагч: Нүгнээ сахина аа. Нүгнээ сахисан зутан ууна гээд би ч гэсэн гүйж л байсан.

Гантулга: Зутан ууна аа, аа за?

Банзрагч: Хурлаа тарахлээр.

Гантулга: Аан зутан ууна.

Банзрагч: Тийм.

Гантулга: Наадамтай том хурал шашны баяр болдог байсан уу?

Банзрагч: Үгүй ээ бас нэг хүүхдүүд барилдаж байна энэ тэр гээд, тэр Мэргэн ванд очиж барилдана гээд явж байсан.

Гантулга: Та бол цогчин дуган , Чойрын дацангийн л хүн юм байна тийм ээ?

Банзрагч: Тийм.

Гантулга: Цогчин дугандаа хурдаг, Чойрын дацандаа бас хурж байсан тийм ээ?

Банзрагч: Тийм. Нэг нэг жил суугаад л , тэгээд л ...Нэг нэг зиндаа хүрсэн үү яасан, Чойрт бол анхны зиндаа дөнгөж хүрээд л больчихсон.

Гантулга: Дацангийн өдөр бүрийн хурал гээд л цогчингоосоо өөр байна уу, адилхан байна уу?

Банзрагч: Үгүй одоо мэдэхгүй юм.

Гантулга: Тэрийг мэдэхгүй байна уу?

Банзрагч: Үгүй.

Гантулга: Сүм хийдүүдийг нь ер нь ямар материалаар барьсан бэ, тоосгоор уу эсвэл модоор уу?

Банзрагч: Үгүй дан тоосго.

Гантулга: Дөрвөлжин байх уу, дугуй хэлбэртэй?

Банзрагч: Дөрвөлжин. Дандаа дөрвөлжин. Их жанлав манлаантай гоё барьсан.

Гантулга: Тэр Чойрын дамжаа барихад ямар шалгалт шүүлэг өгдөг байсан юм бол?

Банзрагч: Аан?

Гантулга: Тэр Чойрын дамжаа барихад ямар шалгалт шүүлэг өгдөг байсан юм бол?

Банзрагч: Үгүй одоо тэр Чойрынхоо номыг л харьцаж л одоо бие биенээсээ давж л тэгдэг бололтой юм.

Гантулга: Ямар хугацаанд хичнээн хүн дамжаа барьдаг байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Банзрагч: Өө тэр гол мөрөн дотор бо дөрвөн хүн суудаг байсан юм. Дөрвөн лам л одоо хөдөлгөөнгүй тонгойгоод сууж байдаг юм. Тэгээд л өнөө дамжаанд орж байгааг чинь аашлаад л , загнаад л юмаа бичээд л . Нэг ойртоод л , нэг холдоод л бөгсөөрөө яваад л , дахиад л алга ташиад л ... Тэгээд л тэр дөрвөн хүн чинь заримдаа арай илүү гарахад нь уурлана, заримдаа бусад нь дэмжээд л .. Тэр тэгсэн байдаг юм, үгүй ээ тэгээгүй , тэр тэгэх үү , тэгж болох үү ингээд л бие биенийгээ мэдлэх гэж байгаа амьтай, тэгж л байгааг нь сайн мэддэг юм.

Гантулга: Тэр олон зиндаа байсан болов уу?

Банзрагч: Аан?

Гантулга: Олон зиндаа байсан болов уу?

Банзрагч: Аа тэр зиндааных нь улс наад хамрын Чойрд байхад арвад хоёр лав байсан байх. Тэр гавж болж байгаа хүндээ тэр зиндааных нь улс ирж уулзаж барьж, бие чинь яаж байна энэ тэр гээд их юм асууна. За тэгээд чи ч юугаа хариулах вэ дээ, хүний дэргэд л байсан байлгүй гээд л тоглоом хийж л байдаг юм.

Гантулга: Тэр ойрхон байсан Өлгий хийд, бусад хийдтэ йямар харилцаа холбоотой байсан, очиж ном хаялцдаг байсан уу, ирж том хурлууд хурдаг байсан уу?

Банзрагч: Аа ганц нэг ирнэ.

Гантулга: Аль хурлаас ирэх үү?

Банзрагч: Өлгийгөөс л лав ирж байсан. Ном хаялдаг байсан. Тэр зиндааных нь улсууд бололтой юм, зиндааных нь улс л байдаг бололтой юм ном хаялцах юм билээ.

Гантулга: Хүрээ рүү ч юмуу, Төвд, Энэтхэг рүү , Баруун зуу рүү ч юмуу ном сурахаар , эргэл мөргөл хийхээр ч юмуу лам нар явдаг байсан уу?

Банзрагч: Ээ явдаг байсан байх. Тэр бүүрэг үүрээд явсан, яаж очсон бол доо зайлуул, амьд очсон болов уу гэж ярьдаг л байсан юм.

Гантулга: Олон жастай байсан уу, Хоньчийн хийд?

Банзрагч: Аан?

Гантулга: Жас, хурлын жасууд?

Банзрагч: Аан жас уу, олон байсан.

Гантулга: Хэдэн жастай байсан бол?

Банзрагч: Цогчин жас, Дүйнхор жас, Чойр жас тэгээд Жүдийн жас гэж байсан. Мамба жас , лав л миний дуулснаар таван жас лав байж.

Гантулга: Жас нь мал толгой олон байсан уу?

Банзрагч: За малтай байсан байх аа. Тэр чинь Жүдийн жасын тэмээ хариулж байгаа, Цогчингийн адуу хариулж байгаа гэж хүмүүс ярьдаг л байсан.

Гантулга: Лам нар нь хаагуур нь гэр орон сууц нь байсан бэ, хурлынхаа?

Банзрагч: Хийдийнхээ хоёр эгнээлж гудамлаад л зун нэг муу амбаарт, өвөл гэрт сууна